

7-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ЖИШИГ ДААЛГАВАР

А-Хувилбар

Хугацаа: 50 минут

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: / Даалгавар тус бүр 1-2оноо /

- Хий шингэн төлөвт шилжих үзэгдлийггэнэ.
 а. Хайлах б. Хөлдөх в. Буцлах г. Конденсаци д. Уурших
- Хүснэгтэнд бодисын нэр болон түүний найрлагыг харуулжээ. Хэд нь химийн нэгдэл болохыг тодорхойл.

Бодисын нэр	Найрлага	Элемент	Нэгдэл
Хүчилтөрөгч	Хүчилтөрөгч		
Ус	Устөрөгч, хүчилтөрөгч		
Натри	Натри		
Хүхрийн оксид	Хүхэр, хүчилтөрөгч		
Төмрийн сульфид	Төмөр, хүхэр		

а. 1 б. 2 в. 3 г. 4 д. 5

- Металлын шинжид аль нь хамаарах вэ?
 а.Хатуу, шингэн хий төлөвтэй б.Хэврэг, хялбархан бутардаг
 в.Цахилгаан дамжуулдаггүй г.Гялалздаг, уян хатан, давтагддаг
- Төмрийн зэв ямар орчинд үүсдэг вэ?
 а. Төмөр + Хүчилтөрөгч → Төмрийн оксид
 б. Төмөр + Хүчилтөрөгч + Ус → Төмрийн оксид
 в. Төмөр + Хүчил → Давс + Устөрөгч
 г. Төмөр + Нүүрстөрөгч → Төмрийн оксид
 д. Төмөр + Хүчилтөрөгч + Устөрөгч → Төмрийн оксид
- Газарзүйн байрлалаас хамаарч усны буцлах цэг өөр өөр байдаг. Дараах графикийг ажиглан ямар газрын ус хамгийн бага температурт буцалж байна вэ?



- а. Улаанбаатар хот б. Алтай хот в. Хөх нуурын хотгор
 г. Эверестийн оргил д. Хүйтэн оргил

- Хөрсний химийн найрлагын графикийг ажиглан эрдэс бодис хэдэн хувийг эзэлж байна вэ?

- а. 50% б. 57% в. 47% г. 40% д. 37%

- Хүрээлэн буй орчны бохирдолын эх үүсвэрийг нэрлэнэ үү.


- а. Агаар б. Ус в. Ургамал г. Мод д. Машины утаа

- Диффузын жишээ аль нь вэ?

- а. Асгарсан сүүг гал тогооны алчуурт шингээж авах б. Дулаан өрөөнд зайрмаг хайлах
 в. Салхи үлээхэд цэцгийн тоос унах г. Тасалгаанд хоолны үнэр тархах
 д. Ус хөлдөх

- Хлоридыг ямар хүчлээс гарган авах вэ?

- а.Устөрөгчийн хлоридын хүчил б. Хүхрийн хүчил в.Нүүрсний хүчил г:Нүүрсхүчлийн хий



10. Металл+ Давсны хүчил → ? + устөрөгч гэсэн схем өгөгджээ. Асуултын тэмдэгийн оронд ямар бодис үүсэх вэ?
а. оксид б. гидроксид в. хүчил г. давс д. элемент
11. Химийн урвалаас үүсэж байгаа бодисыг
а. Бүтээгдэхүүн бодис б. Холимог бодис в. Цэвэр бодис
г. Эх бодис д. Цэвэр бодис
12. Метилоранж индикатор нь хүчлийн уусмалд ямар өнгө үзүүлэх вэ?
а. Өнгөгүй б. Ягаан в. Шар г. Улбар шар д. Улаан
13. Зэвийг ахуйн нөхцөлд дараах боломжуудаас алинаар нь арилгавал зохих вэ?
а. Нимбэгний шүүс б. Ус в. Шохой г. Алчуур д. Төмрөөр
14. Шинж чанараараа аль нь сондгой вэ?
а. Алт б. Төмөр в. Кали г. Зэс д. Натри
15. Хүний үйл ажиллагааны улмаас янз бүрийн химийн бодис, ахуйн болон үйлдвэрийн хаягдал хөрсөнд шингэж, ургамал, амьд организмд сөрөг нөлөө үзүүлэх, хуримтлагдах үзэгдлийггэнэ.
а. Усны бохирдол б. Хөрсний бохирдол в. Агаарын бохирдол
г. Далайн бохирдол д. Дуу чимээний бохирдол
16. Кали, кальци, хүхэр, цахиур, магни гэсэн химийн элементийн тэмдэгийг зөв дарааллаар байрлуулсныг ол.
а. Na, K, Mg, S, Si, б. Na, K, Mg, Si, S в. K, Mg, Si, S, Ca,
г. Si, S, Ca, K, Mg д. K, Ca, S, Si, Mg
17. Төмөр ба хүхрийн холимогийн төрлийг тодорхойлно уу
а. Суспенз
б. Коллоид
в. Механик холимог
г. Уусмал
д. Элемент



18. Элементийн шатах урвалын үр дүнд аль нь үүсэх вэ?
а. Давс үүснэ б. Хүчил үүснэ в. Оксид үүснэ г. Суурь үүснэ
19. Хөрс ньгэсэн бүрэлдэхүүнтэй байна.
а. Элс, лаг шороо, шавар б. Элс в. Лаг шороо
г. Шавар д. Элс, шавар

ХОЁРДУГААР ХЭСЭГ: / Даалгавар тус бүр 3 оноо /

20. Дараах элементийг металл, металл бишээр ангилж бичнэ үү? (3 оноо)

Натри, магни, хлор, устөрөгч, хүхэр, кальци

Металл

Металл биш

21. Дараах өгөгдлийг ашиглан шатах урвалын тэгшитгэл бичнэ үү. (3 оноо)

а. Магни шатаж магнийн оксид үүсгэсэн.

.....

б. Нүүрстөрөгч шатаж нүүрстөрөгчийн (IV) оксид үүсгэсэн.

.....

в. Хөнгөнцагаан шатаж хөнгөнцагааны оксид үүссэн.

.....

22. Багш нэгэн сурагчдад 3 хуруу шилтэй өнгөгүй уусмал өгчээ. Сурагч хуруу шил тус бүр дээр өөр өөр индикатор буюу фенолфталайн, метилоранж, универсаль индикаторуудыг ашиглажээ.

Ажиглалтын үр дүнд:

1-р хуруу шил – ягаан Фенолфталайн

2-р хуруу шил – улбар шар метилоранж

3-р хуруу шил – универсаль индикатор улаан өнгөнүүдийг үзүүлсэн бол анхны уусмалууд ямар орчинтой уусмал байсан бэ?

1- р хуруу шилний орчин:

2- р хуруу шилний орчин:

3- р хуруу шилний орчин: (3 оноо)


23. Хөрсийг бохирдуулагч гол эх үүсвэрээс 3-ыг бичиж, сөрөг талуудыг нь нэрлээрэй. (3 оноо)

а)

б)

с)

24. Дараах зургийг ажиглан доорх даалгавруудыг хийж гүйцэтгэнэ үү. (3 оноо)



а. Ямар нөхцөлд төмөр хадаас зэврэхгүй вэ? Яагаад?

..... (1 оноо)

б. Төмрийн зэврэлд гол үүрэгтэй оролцож буй бодисуудыг тодорхойлж, төмөр зэврэх урвалын тэгшитгэлийг бичнэ үү.

..... (2 оноо)

Анги овог нэр:

Авбал зохих оноо:

Авсан оноо:

Гүйцэтгэлийн хувь:

Түвшин:

А-Хувилбар

7-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ЖИШИГ ДААЛГАВАРЫН ТҮЛХҮҮР

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ:

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19
г	в	г	б	г	в	д	г	а	г	а	д	а	б	б	д	в	в	а

ХОЁРДУГААР ХЭСЭГ:

20.Металл: Натри, магни, кальци

Металл биш: хлор, устөрөгч, хүхэр

21. а. Магни + Хүчилтөрөгч → Магнийн оксид

б. Нүүрстөрөгч + Хүчилтөрөгч → Нүүрсхүчлийн хий, эсвэл Нүүрстөрөгчийн (IV) оксид

в. Хөнгөнцагаан + Хүчилтөрөгч → Хөнгөнцагааны оксид

22. 1-р хуруу шил: Суурилаг бодис

2-р хуруу шил: Саармаг бодис

3-р хуруу шил: Хүчиллэг бодис

23. Эх үүсвэр: Ил жорлон, бохир ус, хог хаягдал, автомашинаас гарч буй утаа, алт олдворлолт гэх мэт олон ялгаатай хариултууд байж болно.

Сөрөг тал: Бие организмд өөрчлөгдөнө. Хүнсний бүтээгдэхүүний чанар муудна. Эрүүл мэндэд сөрөг нөлөөлнө гэх мэт ялгаатай хариулаж болно.

24. а. Ус , агаар

б. Төмөр + Хүчилтөрөгч + Ус → Төмрийн оксид

Материал боловсруулсан Химийн багш Г.Нарантуяа

7-Р АНГИЙН ХИМИЙН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

Б-Хувилбар

Хугацаа: 50 минут

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: / Даалгавар тус бүр 1-2 оноо /

20. Хатуугаас шингэн төлөвт шилжих үзэгдлийггэнэ.

- а. Хайлах б. Хөлдөх в. Буцлах г. Конденсаци д. Уурших

21. Хүснэгтэнд бодисын нэр болон түүний найрлагыг харуулжээ. Хэд нь химийн элемент байгаа болохыг тодорхойл.

Бодисын нэр	Найрлага	Элемент	Нэгдэл
Хлор	Хлор		
Хоолны давс	Натри, хлор		
Төмөр	Төмөр		
Магнийн оксид	Магни, хүчилтөрөгч		
Төмрийн сульфид	Төмөр, хүхэр		

- а. 1 б. 2 в. 3 г. 4 д. 5

22. Металл бишийн шинжид аль нь хамаарах вэ?

- а.Хатуу, хий төлөвтэй, уян хатан б.Хэврэг, хялбархан бутардаг
в.Цахилгаан дамжуулдаггүй, гялантай г.Гялалздаг, уян хатан, давтагддаг

23. Металлыг зэврэлээс хамгаалах аргад хамаарахгүй аргыг нэрлэ.

- а. Будах б. Шатаах в. Тослох г. Лентээр ороох д. Металлаар бүрэх


24. Газарзүйн байрлалаас хамаарч усны буцлах цэг өөр өөр байдаг. Дараах графикийг ажиглан ямар газрын ус хамгийн өндөр температурт буцалж байна вэ?



- а. Улаанбаатар хот б. Алтай хот в. Хөх нуурын хотгор г. Эверестийн оргил д. Мумбай

25. Хөрсний химийн найрлагын графикийг ажиглан агаар хэдэн хувийг эзэлж байна вэ?

- а. 50% б. 57% в. 47% г. 40% д. 25%



26. Аль тохиолдолд хөрс бохирдох вэ?

- а. Ургамал ургуулах б. Цэвэр ус асгах в. Хог хаях г. Бороо орох


27. Диффузын жишээ аль нь вэ?

- а. Асгарсан сүүг гал тогооны алчуурт шингээж авах б. Сахар уусах
в. Салхи үлээхэд цэцгийн тоос унах г. Ус асгарах д. Ус хөлдөх

28. Шинж чанараараа аль нь сондгой вэ?

- а. Алт б. Магни в. Мөнгөнүс г. Зэс д.Цайр

29. Металл + Хүхрийн хүчил → ? + Устөрөгч гэсэн схем өгөгджээ. Асуултын тэмдэгийн оронд ямар бодис үүсэх вэ?
 а. Металлын хлорид б. Гидроксид в. хүчил г. Металлын сульфат д. элемент
30. Химийн урвалд орж байгаа бодисыг
 а. Бүтээгдэхүүн бодис б. Холимог бодис в. Цэвэр бодис
 г. Эх бодис д. Цэвэр бодис
31. Фенолфталеин индикатор нь хүчлийн уусмалд ямар өнгө үзүүлэх вэ?
 а. Өнгөгүй б. Ягаан в. Шар г. Улбар шар д. Цэнхэр
32. Төмрийн зэв ямар орчинд үүсдэг вэ?
 а. Төмөр + Хүчилтөрөгч → Төмрийн оксид
 б. Төмөр + Хүчилтөрөгч + Ус → Төмрийн оксид
 в. Төмөр + Хүчил → Давс + Устөрөгч
 г. Төмөр + Нүүрстөрөгч → Төмрийн оксид
 д. Төмөр + Хүчилтөрөгч + Устөрөгч → Төмрийн оксид
33. Зэвийг ахуйн нөхцөлд дараах боломжуудаас алинаар нь арилгавал зохих вэ?
 а. Нимбэгний шүүс б. Ус в. Шохой г. Алчуур д. Төмрөөр
34. Орчноо зүлэгжүүлж, мод тарих нь ач холбогдолтой
 а. Агаар цэвэрших б. Эрүүл мэндэд в. Гоё харагддаг г. Бүгд зөв
35. Магни, цахиур, хүхэр, кальци, кали гэсэн химийн элементийн тэмдэгийг зөв дарааллаар байрлуулсныг ол.
 а. Na, K, Mg, S, Si, б. Mg, Na, K, Si, S в. Mg, Si, S, Ca, K
 г. Si, S, Ca, K, Mg д. K, Ca, S, Si, Mg
36. Химийн тэмдэг нь “Силициум” дуудлага бүхий элементийн нэр нь :
 а. Mg б. K в. Ca г. Si д. S
37. Хүний үйл ажиллагааны улмаас янз бүрийн химийн бодис ахуйн болон үйлдвэрийн хаягдал хөрсөнд шингэж ургамал амьд организмд сөрөг нөлөө үзүүлэх үзэгдлийг гэнэ.
 а. агаарын бохирдол б. хөрс в. усны бохирдол г. хөрсний бохирдол
38. Сурагч хөрсний рН-ийг судалсан үр дүнг диаграммаас харна уу. Хөрсний саармаг байх үеийг сонгоно уу.



- а. А
 б. В
 в. С
 г. В ба С
 д. А ба В

ХОЁРДУГААР ХЭСЭГ: / Даалгавар тус бүр 3 оноо /

39. Дараах элементийг металл, металл бишээр ангилж бичнэ үү? (3 оноо)

Кали, хөнгөнцагаан, нүүрстөрөгч, магни, фосфор, азот

Металл:

Металл биш:

21. Дараах өгөгдлийг ашиглан шатах урвалын тэгшитгэл бичнэ үү. (Тус бүр 1 оноо)

а. Кальци шатаж кальцийн оксид үүсгэсэн.

б. Хүхэр шатаж хүхрийн (IV) оксид үүсгэсэн.

в. Лити шатаж литийн оксид үүсгэсэн.

22. Багш нэгэн сурагчдад 3 хуруу шилтэй өнгөгүй уусмал өгчээ. Сурагч хуруу шил тус бүр дээр өөр өөр индикатор буюу 1-р хуруу шилэнд фенолфталеин, 2-р хуруу шилэнд метилоранж, 3-р хуруу шилэнд универсаль индикаторуудыг дусаажээ. Ажиглалтын үр дүнд:

1-р хуруу шил – өнгөгүй

2-р хуруу шил – улаан

3-р хуруу шил – ногоон өнгөнүүдийг үзүүлсэн бол анхны уусмалууд ямар орчинтой уусмал байсан бэ?

4- р хуруу шилний орчин:

5- р хуруу шилний орчин:

6- р хуруу шилний орчин:(3 оноо)


23. Хөрсийг бохирдлоос хамгаалах 3 арга замыг бичнэ үү. (3 оноо)

d)

e)

c)

24. Дараах зургийг ажиглан доорх даалгавруудыг хийж гүйцэтгэнэ үү.



Төмөр (хадаас)-ийн зэврэлийг турших нөхцлүүдийг зурагт харуулжээ. Үүнд:
1-усанд хадаас хагас дүрэгдсэн, таглаагүй.
2-кальцийн хлоридтой, таглаатай.
3-халуун ус, дээрээ тосон үетэй.
4-усанд хадаас дүрэгдсэн, таглаагүй.

а. Ямар нөхцөлд төмөр хадаас зэврэхгүй вэ? Яагаад?

.....(1 оноо)

б. Төмрийн зэврэлд гол үүрэгтэй оролцож буй бодисуудыг тодорхойлж, төмөр зэврэх урвалын тэгшитгэлийг бичнэ үү.

.....(2 оноо)

Анги овог нэр:

Авбал зохих оноо:

Авсан оноо:

Гүйцэтгэлийн хувь:

Түвшин:

Б-Хувилбар

**7-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ЖИШИГ ДААЛГАВАРЫН ТҮЛХҮҮР
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ:**

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19
а	б	б	б	д	д	в	б	в	г	г	а	б	а	а	в	г	г	б

ХОЁРДУГААР ХЭСЭГ:

- 20.Металл: кали, хөнгөнцагаан, магни
Металл биш: нүүрстөрөгч, фосфор, азот
21. а. Кальци + Хүчилтөрөгч → Кальцийн оксид
б. Хүхэр + Хүчилтөрөгч → Хүхрийн оксид
в. Лити + Хүчилтөрөгч → Литийн оксид
22. 1-р хуруу шил: Суурилаг бодис
2-р хуруу шил: Хүчиллэг бодис
3-р хуруу шил: Саармаг бодис
23. Хог хаягдлыг бууруулах-ил задгай хаяхгүй байх
Мод тарих
24. а. Ус , агаар
б. Төмөр + Хүчилтөрөгч + Ус → Төмрийн оксид

Б-Хувилбар

**7-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ЖИШИГ ДААЛГАВАРЫН ТҮЛХҮҮР
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ:**

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19
а	б	б	б	д	д	в	б	в	г	г	а	б	а	а	в	г	г	б

ХОЁРДУГААР ХЭСЭГ:

- 20.Металл: кали, хөнгөнцагаан, магни
Металл биш: нүүрстөрөгч, фосфор, азот
21. а. Кальци + Хүчилтөрөгч → Кальцийн оксид
б. Хүхэр + Хүчилтөрөгч → Хүхрийн оксид
в. Лити + Хүчилтөрөгч → Литийн оксид
22. 1-р хуруу шил: Суурилаг бодис
2-р хуруу шил: Хүчиллэг бодис
3-р хуруу шил: Саармаг бодис
23. Хог хаягдлыг бууруулах-ил задгай хаяхгүй байх
Мод тарих
24. а. Ус , агаар

б. Төмөр + Хүчилтөрөгч + Ус → Төмрийн оксид

Материал боловсруулсан Химийн багш Г.Нарантуяа